

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/21/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас: 261740 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	20
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.4.1 Завсрын аудитын талаар	21
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил	24
5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил	24
5.2.1 Албан шаардлага	24
5.2.2 Зөвлөмж.....	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТББ	Төрийн бус байгууллага
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЗДХС	Хууль, зүй дотоод хэргийн сайд
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХНХСҮСХүрээлэн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны хүрээлэн
ХАХНХССХ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн
ХҮТ	Худалдаа үйлчилгээний төв
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.БАУЫРЖАН ТАНАА

2026.03.25 № 798
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 74,592.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Дамжуулан зээлээр олгосон өмнөх оны авлагаас 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөгийг барагдуулж, 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг аваагүй;
2. Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд аймаг, нийслэлийн иргэн, аж ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 8,256.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
3. Санхүүгийн дэмжлэгээр 2022 онд орон нутаг, нийслэлийн 4,420 иргэн аж, ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон 14,342.0 сая төгрөгийн зээлээс тайлант онд 2,154 иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа хэтэрсэн нийт 6,574.4 сая төгрөгийн авлага үүссэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, холбогдох журамд заасны дагуу эргэн

төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй;

4. Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтааж аж ахуйн нэгжүүдэд олгоогүй, холбогдох журмыг зөрчин он дамжуулан 6,350.0 сая төгрөгийг 108 аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлсэн;
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2003-2017 оны хооронд олгосон жижиг зээлийн өмнөх оны 429.0 сая төгрөгийн авлагаас тайлант онд 7.3 хувь буюу 31.5 сая төгрөгийг барагдуулж, 397.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, 29.9.13, 30.1.6, Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.8, Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.3, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.7, 6.4, 6.11, Засгийн газрын баталсан 2023 оны "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам"-ын 99 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5, 3.7, 4.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөрийн хувийн 55 биржид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 789.4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Үүнд: Ажил хайгч ажилгүй 620 иргэнийг ажилд зуучлахад 29.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 16 иргэнийг ажилд зуучлан 1.7 сая төгрөг, ажил олоход хүндрэлтэй 136 иргэнийг ажилд зуучлан 8.3 сая төгрөг, бүлгийн зөвлөгөө өгөх буюу ерөнхий боловсролын сургуулийн сурагч нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх ажил үйлчилгээнд 1,766 иргэн хамрагдаж, 477.1 сая төгрөг, хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ хийлгэхэд 3,910 иргэн хамрагдаж, 74.3 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулахад 2,672 иргэн хамрагдаж, 33.9 сая төгрөг, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг ажил хайгч ажилгүй 7,533 иргэн хамрагдаж, 137.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 445 иргэн хамрагдаж, 11.9 сая төгрөг, ажил олоход хүндрэлтэй 646 иргэн хамрагдаж, 15.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн" худалдаа, үйлчилгээний төвийн барилгад гал гарсны улмаас хохирсон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 40, 41 дүгээр тогтоол, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 09 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 5,200.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэж, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан тус худалдааны төвийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч, түрээслэгч 245 иргэнд нийт 4,852.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Бусад асуудлын хэсэг

“Төрөөс хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих” өдөрлөгийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулжээ.

Төрийн албан хаагчдаас чөлөөлөгдсөн болон ажлын байраа өөрчлөх хүсэлттэй ажлын дадлага, туршлагатай төрийн албан хаагч болон иргэдийг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах, холбон зуучлах замаар хөдөлмөрийн зах зээлд дахин ажилд оруулах боломжийг нэмэх, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, аж ахуйн нэгжийн бизнес, үйл ажиллагааны тогтвортой, тасралтгүй байдлыг хангах зорилгоор зохион байгуулсан өдөрлөгт 22 аж ахуйн нэгж, байгууллага 1,117 нээлттэй ажлын байрыг танилцуулж, 300 төрийн албан хаагч, иргэд оролцсон байна. Давхардсан тоогоор 822 иргэн, төрийн албан хаагч хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл, зөвлөгөө авч, 229 хүн ажлын байранд шинээр бүртгүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		362,359,313.2	544,742,088.0
2	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	362,322,763.2	544,705,538.0
3	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	36,550.0	36,550.0
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		362,359,313.2	544,742,088.0
5	НИЙТ ӨР ТӨЛБӨР		30,060,809.6	29,210,429.8
6	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	17,446,743.4	18,732,768.6
7	Өглөг	17а, 17б	14,192.9	7,344,993.9
8	Урьдчилж орсон орлого	18а, 18б	17,432,550.4	11,082,535.8
9	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,614,066.3	10,477,661.2
10	Урт хугацаат зээл	20а, 20б	12,614,066.3	10,477,661.2
11	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		332,298,503.6	515,531,658.2
12	Засгийн газрын хувь оролцоо		332,298,503.6	515,531,658.2
13	Хуримтлагдсан үр дүн		332,298,503.6	515,531,658.2
14	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		362,359,313.2	544,742,088.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		144,860,556.7	211,031,260.6
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	144,732,551.7	211,031,260.6
3	Нийтлэг татварын бус орлого		144,732,551.7	206,177,636.6
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		128,005.0	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	23,656,463.8	27,699,920.1
6	УРСГАЛ ЗАРДАЛ		23,656,463.8	27,699,920.1
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,414,523.7	3,401,962.2
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,286,780.7	3,401,962.2
9	Бараа үйлчилгээний бусад зардал		127,743.0	-
10	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		19,241,940.1	24,297,957.8
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		121,204,092.9	183,331,340.6
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(9,547,306.9)	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		111,656,785.9	183,331,340.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,716,207.7	-	220,716,207.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(74,490.0)	-	(74,490.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	220,641,717.7	-	220,641,717.7
4	Тайлант үеийн үр дүн	111,656,785.9	-	111,656,785.9
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,298,503.6	-	332,298,503.6
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(98,186.0)	-	(98,186.0)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	332,200,317.6	-	332,200,317.6
8	Тайлант үеийн үр дүн	183,331,340.6	-	183,331,340.6
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	515,531,658.2	-	515,531,658.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	269,197,920.8	390,640,626.7
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	242,840,693.3	390,640,626.7
3	Нийтлэг татварын бус орлого	242,840,693.3	385,787,002.7
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,357,227.5	-
5	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	259,650,613.9	446,460,737.7
6	УРСГАЛ ЗАРДАЛ	259,650,613.9	446,460,737.7
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,373,816.7	3,006,072.9
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,246,201.7	3,006,072.9
9	Бараа үйлчилгээний бусад зардал	127,615.0	-
10	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	255,276,797.1	443,454,664.9
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,547,306.9	(55,820,111.0)
12	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	51,995,731.6
13	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	-	691,258.3
14	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	9,547,306.9	(3,133,121.1)
15	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	13,000,000.0	-
16	Бусад гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	13,000,000.0	-
17	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(9,547,306.9)	55,820,111.0
18	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	47,574,129,100.00	193,380,572,185.93	145,806,443,085.93	406.5
12	Татварын бус орлого	47,574,129,100.00	193,380,572,185.93	145,806,443,085.93	406.5
120	Нийтлэг татварын бус орлого	47,574,129,100.00	193,380,572,185.93	145,806,443,085.93	406.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	43,985,769,100.00	184,077,271,855.29	140,091,502,755.29	418.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	3,588,360,000.00	9,303,300,330.64	5,714,940,330.64	259.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	129,921,724,600.00	50,924,152,951.50	78,997,571,648.50	39.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,936,000,800.00	54,057,274,035.29	34,878,726,764.71	60.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,374,973,200.00	3,006,072,870.80	9,368,900,329.20	24.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,374,973,200.00	3,006,072,870.80	9,368,900,329.20	24.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,374,973,200.00	3,006,072,870.80	9,368,900,329.20	24.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,561,027,600.00	51,051,201,164.49	25,509,826,435.51	66.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,561,027,600.00	51,051,201,164.49	25,509,826,435.51	66.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	76,561,027,600.00	51,051,201,164.49	25,509,826,435.51	66.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,985,723,800.00	(3,133,121,083.79)	44,118,844,883.79	(7.6)
230001	Эргэж төлөгдөх зээл	40,985,723,800.00	(3,133,121,083.79)	44,118,844,883.79	(7.6)
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(82,347,595,500.00)	142,456,419,234.43	(224,804,014,734.43)	(173.0)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,347,595,500.00	(142,456,419,234.43)	224,804,014,734.43	(173.0)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	82,347,595,500.00	(142,456,419,234.43)	224,804,014,734.43	(173.0)

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,853,624,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,853,624,000.00
122	Тусламжийн орлого	4,853,624,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	4,853,624,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,853,624,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,852,889,000.0
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	735,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,852,889,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,852,889,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,852,889,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,852,889,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,852,889,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	735,000.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(735,000.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(735,000.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны стратегийн мөн чанарыг “Хүн амын хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно” гэж тодорхойлсон байна. Тухайлбал:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшнийг бууруулах;
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дэвшүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх;
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас “Хөдөлмөр-Хөгжил” өдөрлөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг БНСУ болон Япон Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад эх орондоо эргэн ирсэн иргэд, мөн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэл сонирхолтой иргэдийг бүртгэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах, сургалтад хамрагдах, бичил бизнес эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулсан байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд “Дагалдан ажиллаж хөдөлмөрт шилжих нь” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсний дагуу зорилтот бүлэгт хүрч ажиллах “Олон талт оролцогчдын платформ”-ыг хэрэгжүүлэх арга замын талаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийн зорилтот бүлэгт хүрч ажиллах оновчтой загвар, шийдлийг тодорхойлох, талуудын оролцоо бүхий платформыг бий болгох талаар санал солилцох зорилготой өнөөдрийн сургалт хэлэлцүүлэгт төслийн баг, ГБХНХЯ, ХХҮЕГ, дүүргийн халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд, ШШГЕГ, Цагдаагийн байгууллага, судлаачид, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа гэрээт ТББ, Иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд оролцсон байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.8-д дэвшүүлсэн “Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан

хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох" зорилтын хүрээнд байгуулагдсан "Жоб центр" төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар Монголын хөдөлмөрийн биржүүдийн холбоо болон ЖОБ центр төвүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан ажилласан байна.

- "Job center" төвийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойш улсын хэмжээнд 14 төв үйл ажиллагаа явуулж, орон нутагт 4 төв /Хэнтий, Дорнод, Хөвсгөл, Сүхбаатар/, УБ хотод 10 төв /СБД-5, БЗД-1, БГД-3, ХУД-1/ тус тус байна. Тус төвүүд нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг 1,256 иргэнд, ажил зуучлах үйлчилгээг 104 иргэнд үзүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сан нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль болон бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаал;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн, аудитын хугацаанд тайлан гараагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2019 онд батлагдсан, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын дагуу шинэчлэл хийгдээгүй.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 544,742.1 сая төгрөг болж, өмнөх оноос 182,382.8 сая төгрөгөөр буюу 50.3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	362,322,763.2	544,705,538.0	182,382,774.8
Бусад эргэлтийн хөрөнгө	36,550.0	36,550.0	-
Нийт хөрөнгийн дүн	362,359,313.2	544,742,088.0	182,382,774.8
Нийт өр төлбөр	30,060,809.6	29,210,429.8	(850,379.8)
Богино хугацаат өр төлбөр	17,446,743.3	18,732,768.6	1,286,025.3
Өглөг	14,192.9	7,650,232.8	7,636,039.9
Урьдчилж орсон орлого	17,432,550.4	11,082,535.8	(6,350,014.6)
Урт хугацаат өр төлбөр	12,614,066.3	10,477,661.2	(2,136,405.1)
Урт хугацаат зээл	12,614,066.3	10,477,661.2	(2,136,405.1)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	332,298,503.6	515,531,658.2	183,233,154.6
Засгийн газрын хувь оролцоо	332,298,503.6	515,531,658.2	183,233,154.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	362,359,313.2	544,742,088.0	182,382,774.8

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс үзэхэд авлага, богино болон урт хугацаат өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн данснуудад материаллаг өөрчлөлтүүд гарсан байна.

3.4.1 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 544,705.5 сая төгрөг болж, өмнөх оноос 182,382.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
A	1	2	3=2-1
Татаас, санхүүжилтийн авлага	211,247,129.0	413,945,771.3	202,698,642.3
Зээлийн хүүгийн авлага	226,654.0	129,635.0	(97,019.0)
Бусад авлага	8,505,933.3	8,827,854.0	321,920.7
Байгууллагаас авах авлага	8,471,500.2	8,793,420.9	321,920.7
Хувь хүмүүсээс авах авлага	34,433.1	34,433.1	-
Зээлийн авлага	142,343,046.9	121,802,277.7	(20,540,769.2)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	109,343,046.9	108,802,277.7	(540,769.2)
Хувь хүмүүст олгосон зээл	94,297,902.3	94,937,276.8	639,374.5
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	15,045,144.6	13,865,000.9	(1,180,143.7)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	33,000,000.0	13,000,000.0	(20,000,000.0)
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,000,000.0	13,000,000.0	(20,000,000.0)
Нийт дүн	362,322,763.2	544,705,538.0	182,382,774.8

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 75.9 хувь буюу 413,945.8 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 22.4 хувь буюу 121,802.3 сая төгрөгийн зээлийн авлага, 1.6 хувь буюу 8,827.8 сая төгрөгийн байгууллага болон хувь хүмүүсээс авах авлага, 0.1 хувь буюу 129.6 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлага тус тус эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдэл 182,382.8 сая төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

ХЭДС нь дамжуулан зээл болон санхүүгийн дэмжлэгээр олгосон хугацаа хэтэрсэн 34,317.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

1. Дамжуулан зээлээр олгосон зээлийн авлага өмнөх оноос 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөгөөр барагдаж, нийт 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл барагдаагүй байна. Үүнд:
 - Оёдлын нэгдсэн холбоонд 2013 онд “Сурагчдын дүрэмт хувцсыг үндэсний үйлдвэрүүдээр үйлдвэрлүүлэх” зорилгоор олгосон зээлийн 15,639.8 сая төгрөгийн үлдэгдэл авлагаас тайлант онд 1,180.1 сая төгрөгийг барагдуулж, 14,459.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
 - Капитал банканд байршуулсан ХЭДС-ийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл нийт 3,865.6 сая төгрөгийн авлагаас 36.6 сая төгрөгийн үнэ бүхий авто тээврийн хэрэгслийг авлагын үлдэгдэлд тооцон авч, 3,829.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
 - ХЭДС-аас ажлын байр бий болгох зорилгоор жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Анод банканд 2005-2008 оны хооронд байршуулсан 800.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй байна.

- ХЭДС-аас Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжид олгосон жижиг зээлийн хугацаа хэтэрсэн зээлийн 429.0 сая төгрөгийн авлагаас 7.3 хувь буюу 31.5 сая төгрөгөөр барагдаж 397.5 сая төгрөгийн авлага байна.
- ХЭДС-аас Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онуудад орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 12,863.8 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт өмнөх оноос 36.0 хувь буюу 4,609.4 сая төгрөгөөр барагдаж, 14,830.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.
- Санхүүгийн дэмжлэгээр 2022 онд орон нутаг, нийслэлийн 4,420 иргэн аж, ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй 14,342.0 сая төгрөгийн олгосон зээлээс тайлант онд хугацаа хэтэрсэн 2,154 иргэн, аж ахуй нэгжийн 6,574.4 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Аудитын илрүүлэлт: ХЭДС-ийн харьяа сангуудад авлага данстай холбоотой нийт 1,179.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд 1,074.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэлтэй хэвээр байна. /Дундговь аймгийн ХЭДС 275.6 сая төгрөг, Завхан аймгийн ХЭДС 624.8 сая төгрөг, Орхон аймгийн ХЭДС 33.4 сая төгрөг, ХУД-ийн ХЭДС 20.8 сая төгрөг, БНД-ийн ХЭДС 2.6 сая төгрөг, БЗД-ийн ХЭДС 2.9 сая төгрөг, НД-ийн ХЭДС 3.0 сая төгрөг, БГД-ийн ХЭДС 17.8 сая төгрөг, БХД-ийн ХЭДС 3.8 сая төгрөг, СХД-ийн ХЭДС 47.3 сая төгрөг, Нийслэлийн ХЭДС 42.5 сая төгрөг/
- Санхүүгийн тайланд тусгасан 92.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй; /Нийслэлийн ХЭДС 69.5 сая төгрөг, Төв аймгийн ХЭДС 22.7 сая төгрөг/
- Тайлант онд 12.9 сая төгрөгийн авлага шинээр үүсгэсэн. /БГД-ийн ХЭДС 11.0 сая төгрөг, СБД-ийн ХЭДС 0.4 сая төгрөг, ЧД-ийн ХЭДС 0.9 сая төгрөг, БХД-ийн ХЭДС 0.6 сая төгрөг/

3.4.2 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 29,210.4 сая төгрөг болж, өмнөх оноос 850.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
А	1	2	3=2-1
Богино хугацаат өр төлбөр	17,446,743.4	18,732,768.6	1,286,025.2
Өглөг	14,192.9	7,650,232.8	7,636,039.9
Бусад өглөг	14,192.9	7,650,232.8	7,636,039.9
Байгууллагад төлөх өглөг	8,194.9	4,218,789.0	4,210,594.1
Хувь хүмүүст төлөх өглөг	5,998.0	3,431,443.8	3,425,445.8
Урьдчилж орсон орлого	17,432,550.4	11,082,535.8	(6,350,014.6)
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	17,432,550.4	11,082,535.8	(6,350,014.6)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,614,066.3	10,477,661.2	(2,136,405.1)
Урт хугацаат зээл	12,614,066.3	10,477,661.2	(2,136,405.1)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	12,614,066.3	10,477,661.2	(2,136,405.1)
Нийт дүн	30,060,809.6	29,210,429.8	(850,379.8)

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 18,732.8 сая төгрөг болж өмнөх оноос 1,286.0 сая төгрөгөөр өссөн нь 2025 онд Сангийн яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтын эрх хаасантай холбоотой байгууллага болон хувь хүмүүст өгөх өглөг нэмэгдсэн байна.

Байгууллагад өгөх өр төлбөрийн үлдэгдэлд 21 аймаг, 9 дүүрэг, ХАХНХССХ, ХХҮЕГ-ын ХЭДС-ийн нийт 4,218.8 сая төгрөг;

Хувь хүмүүст өгөх өр төлбөрийн үлдэгдэлд 21 аймаг, 9 дүүрэг, ХАХНХССХ, ХХҮЕГазрын ХЭДС-ийн нийт 3,431.4 сая төгрөгийн өр бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд ХЭДС-ийн гадаадын иргэний ажлын байрны төлбөрийн 11,082.5 сая төгрөгийн урьдчилж орсон төлбөр бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 10,477.6 сая төгрөгийн Дэлхийн банкнаас авсан жижиг зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: ХЭДС-ийн харьяа сангуудад өр төлбөр данстай холбоотой нийт 189.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, шинээр өр төлбөр үүсгэсэн нийт 189.5 сая төгрөг; /Баянхонгор аймгийн ХЭДС 30.8 сая төгрөг, Төв аймгийн ХЭДС 8.6 сая төгрөг, Орхон аймгийн ХЭДС 150.1 сая төгрөг/

3.4.3 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 515,531.7 сая төгрөг болж, өмнөх оноос 183,233.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
А	1	2	3=2-1
Засгийн газрын хувь оролцоо	332,298,503.6	515,531,658.2	183,233,154.6
Хуримтлагдсан үр дүн	332,298,503.6	515,531,658.2	183,233,154.6
Өмнөх үеийн үр дүн	220,641,717.7	332,200,317.6	111,558,599.9
Тайлант үеийн үр дүн	111,656,785.9	183,331,340.6	71,674,554.7
Дүн	332,298,503.6	515,531,658.2	183,233,154.6

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 515,531.7 сая төгрөг болж өмнөх оноос 183,233.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогоос 54,263.9 сая төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 4,000.0 сая төгрөг, жижиг зээлийн эргэн төлөлт 20,000.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 48,838.4 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 22,900.0 сая төгрөг нийт 150,002.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зарлагыг 150,002.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, саналыг баталсан байна.

Тайлант онд тодотголоор сангийн төсвийг 843.2 сая төгрөгөөр бууруулж, 129,921.7 сая төгрөгөөр төсвийг тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, үйл ажиллагааны 27 арга хэмжээг санхүүжүүлэхээр үйл ажиллагааны орлогоос 43,985.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,588.4 сая төгрөг нийт 47,574.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 184,077.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 9,303.3 сая төгрөг нийт 193,380.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр нийт 50,924.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 142,456.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэн татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 50,924.2 сая төгрөг буюу 39.2 хувьтай байгаа нь Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төслийн батлагдсан арга хэмжээг дутуу зарцуулсан болон 2025 онд Сангийн яамнаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтын эрх хаасантай холбоотой байна.

Хүснэгт 4. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /илүү+, дутуу- /	Бие-лэлт
Код	Нэр				
72102	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	129,921.7	50,924.2	78,997.5	39.2
80224	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл дүүргийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	318.1	27.5	290.6	8.6
80602	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	15,841.9	12,261.6	3,580.3	77.4
82616	Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төсөл	9,289.7	1,459.0	7,830.7	15.7
82619	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	3,530.3	1,670.7	1,859.6	47.3
82620	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	2,518.6	1,218.7	1,299.9	48.4
82621	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	39,844.0	31,560.8	8,283.2	79.2
82622	Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	5,536.5	2,868.9	2,667.6	51.8
82623	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	8,042.6	2,990.1	5,052.5	37.2
81404	Дамжуулан зээлдүүлсэн зээл	(4,014.3)	(3,133.1)	(881.2)	78.0
81405	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	40,985.7	-	40,985.7	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн ХҮТ-ийн барилгад гал гарсны улмаас хохирсон иргэдийг дэмжих ажлын хүрээнд ЗГ-ын 2025 оны 208 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 4,852.9 сая төгрөгийн санхүүжилт авч 100.0 хувь зарцуулсан байна. ХБХХЕГ-ын нэмэлт дансанд 0.7 сая төгрөгийн тендерийн хураамжийн орлогыг зарцуулаагүй улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны 2025 онд худалдан авах ажиллагааны хүрээнд 9 багц бараа ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 43,942.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөн “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулжээ. Үүнд:

1. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч гаргах үйл ажиллагааны системийг шинээр хөгжүүлэх 350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулсан боловч тендер оролцсон байгууллагаас гомдол гарч амжилтгүй болсон.

2. Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем И-ЖОБ платформ, ЖОБ центрийн үйлчилгээний модулийг хөгжүүлэх 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан “Дижитал воркс” ХХК-тай 594.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 1 болон 2 дугаар үе шатын тайланг хүлээн авч, гэрээний дагуу гүйцэтгэлээр 297.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн программын онлайн хөгжүүлэлт хийх 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулж, санхүүгийн программын ашигладаг “Аксplorер” ХХК-тай 19.3 сая төгрөгийн гэрээ байгуулан, гэрээний дагуу урьдчилгаа төлбөр болох үнийн дүнгийн 70-хувьтай тэнцэх 13.5 сая төгрөгийг олгосон.

4. Бүтээмжийн мастер төлөвлөгөө хийх судалгааны ажил 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулагдах байсан боловч хийх ажил нь тодорхойгүй, удирдамж нь гараагүй учраас тендер сонгон шалгаруулалт хийгдээгүй.

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн танилцуулга, гарын авлага, тараах материал хэвлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах 95.0 сая төгрөгийн өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэлээр 93.3 сая төгрөг зарцуулсан байна.

6. Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр арга хэмжээг олон нийтэд түгээн сурталчлах 99.0 сая төгрөгийн өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж гүйцэтгэлээр 79.0 сая төгрөг зарцуулсан байна.

7. Олон улсын стандарт нэвтрүүлэх 250.0 сая төгрөгийн өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан боловч нэг ч байгууллага материал ирүүлээгүй байна.

8. Жижиг зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох 40,985.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулсан боловч Сангийн яамнаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулах эрхийг хаасантай холбоотой шалгарсан Төрийн, Хаан, Худалдаа хөгжлийн банктай гэрээ хийгдээгүй.

9. Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө, дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах 978.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан 8 газартай 782.4 сая төгрөгийн гэрээ байгуулан санхүүжилт олгоогүй өглөгөөр тусгаж тооцоо нийлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ХЭДС, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус сангийн үйл ажиллагааг сайжруулах авлага болон зардлын данс, хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал, аудитор Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

ХЭДС-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/382 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал 33,203.8 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 332.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 7,195.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 4,042.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүлж, 3,152.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1. ХЭДС-уудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн аудитаар мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлдэг нийт 7,146.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 3,993.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3,152.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1. Хөдөлмөрийн хувийн биржийн баримт бичгийг архивын нэгж болгон бүрдүүлж, хавтаслан үдэж хадгалаагүй нь архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох журмыг зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д "албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах", 24 дүгээр зүйлийн 24.1-д "байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална", 24.1.9-д "архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих.", ХЗДХС-ийн баталсан А/100 дугаар тушаалаар баталсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 5.1-д "Архивын хадгаламжийн нэгж нь тодорхой шинжээр ангилан төрөлжүүлж, биет байдлаараа тус тусдаа хадгалагдаж байгаа бүртгэлийн дугаар бүхий нэг буюу хэд хэдэн баримт байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Архивын баримтыг эмх цэгцтэй бүрдүүлэн хадгалах зохион байгуулалтын тогтолцоог сайжруулж, бүх төрлийн ажлын баримтыг шаардлагын дагуу бүрэн баримтжуулах арга хэмжээг авах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 2. Гадаадаас ажиллах хүч авах үйлчилгээний зөвшөөрөл олгох цахим системийг "Ай Түүлс" ХХК гүйцэтгэн 2020 оноос хэрэглээнд нэвтрүүлсэн байна. Аудитаар дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

1. Системийн мэдээллийн санд хандах эрх өнөөг хүртэл тус компанид хадгалагддаг.
2. Тухайн байгууллагын Мэдээллийн технологийн төвөөс системийн ашиглалт, аюулгүй байдал, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд системд нэвтрэх эрх олгогдоогүй, хяналт тавих боломжгүй;

3. Системийн хэвийн үйл ажиллагааг хангах, техник үйлчилгээ, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой үйлчилгээг хөгжүүлэгч компаниар гүйцэтгүүлэх ажил хийгдээгүй;
4. Тус системд нэвтрэлтийн мэдээлэл, өгөгдөлд хийсэн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх лог бүртгэлийн систем бүрэн хөгжүүлэгдээгүй, байгууллагаас хянах боломжгүй байдлаар бүтээгдсэн нь нь мэдээллийн сангийн нууцлал, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын шаардлагыг хангахгүй байх, мөн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-д "Мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх асуудлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхэлж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.", 33.4-д "Мэдээллийн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадаадаас ажиллах хүч авах үйлчилгээний зөвшөөрөл олгох цахим системийг гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авах ажиллагааг эрчимтэй зохион байгуулж, тус системийг хөгжүүлэх, сайжруулах талаар арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өглөө.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

ХЭДС-ийн 2025 оны II улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 17.8 сая төгрөгийн 1 алдааг илрүүлснээс аудитын явцад залруулан, 7,001.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 5 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтаагаагүй он дамжуулан 6,350.0 сая төгрөгийг 109 аж ахуй нэгж, байгууллагад шилжүүлсэн;
- 1. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн хариуцсан газраас хүргүүлсэн ажлын байрны төлбөрийн буцаалт олгох хүсэлтийн тооцоолол болон ХЭДС-ийн санхүү хариуцсан мэргэжилтний тооцоолол 540.3 сая төгрөгөөр зөрүүтэй байгааг хариуцсан 2 нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь дараагийн шатны санхүүгийн болон дотоод хяналт сул байгаагаас шалтгаалан ажлын байрны буцаалтын төлбөр аж ахуй нэгж байгууллагад үнэн зөв олгогдохгүй эрсдэлтэй;
- 2. ХЭДС-ийн И-зөвшөөрөл буюу гадаадаас ажиллах хүч авах системд ажлын байрны төлбөрийн зөрүүгийн буцаалтын тооцоолол болон хугацааг тооцох модуль байхгүйн улмаас эксель программ дээр гараар бүртгэж байгаа нь үнэн зөв тооцоолол хийгдэхгүй байх, алдаа гарах эрсдэлтэй;
- ХЭДС-нд төвлөрүүлэх гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлого жил бүр ХХҮЕГ-ын төрийн сангийн харилцах дансанд данс андуурагдан төвлөрч байна, тайлант хугацаанд 82 аж ахуй нэгж нийт 769.5 сая төгрөг ХХҮЕГ-ын дансаар дамжуулан ХЭДС-д төвлөрүүлсэн байна. Тайлант хугацаанд ХХҮЕГ-ын харилцах данс руу ХЭДС-ийн ажлын байрны төлбөрийн орлого болох данс андууран орж ирсэн 54.0 сая төгрөгийн орлогыг ХЭДС руу дутуу шилжүүлсэн;

- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлаас эдийн засгийн ангилал зөрчин хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр танилцуулга, сурталчилгааны постер бэлтгэх, түгээх зардалд 13.9 сая төгрөг, хөдөлмөрийн биржийн сургалт, багшийн хөлсөнд 6.3 сая төгрөгийг зарцуулсан зөрчлийн давтан гаргаагүй байна.
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 2016 онд үүссэн 2,565.6 сая төгрөгийн авлагаас 2024 онд авлагад тооцож авсан 36.6 сая төгрөгийн үнэ бүхий борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй, ашиглалтгүй хадгалагдаж байна.

Завсрын аудитаар илэрсэн зөрчлөөс арилгах боломжгүй дараах зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтааж аж ахуйн нэгжүүдэд олгоогүй, холбогдох журмыг зөрчин он дамжуулан 6,350.0 сая төгрөгийг 108 аж ахуй нэгж, байгууллагад шилжүүлсэн байна. Тухайлбал: Чайна энерги инженеринг групп ХХК-ээс 2024 оны ажлын байрны төлбөр болох 3,857.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 2024 оны оны 11 дүгээр сарын 29-ний хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хүсэлтийг гаргасан боловч холбогдох журмыг зөрчин 2025 оны 4 дүгээр сард 2,206.7 сая төгрөгийг олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Тайлант онд ХЭДС-ийн үндсэн үйл ажиллагааны орлого болох гадаад ажилтны ажлын байрны төлбөрт 215,362.0 сая төгрөгийн орлогыг аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрч, холбогдох журмын дагуу 25,545.1 сая төгрөгийн хөнгөлөлт, буцаалтын төлбөрийг олгожээ. Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Тухайлбал:
 - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн хариуцсан газраас хүргүүлсэн ажлын байрны төлбөрийн буцаалт олгох хүсэлт болон ХЭДС-ийн санхүү хариуцсан мэргэжилтний тооцоолол 547.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгааг хариуцсан 2 нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь дараагийн шатны санхүүгийн болон дотоод хяналт сул байгаагаас шалтгаалан ажлын байрны буцаалтын төлбөр аж ахуй нэгж байгууллагад үнэн зөв олгогдохгүй эрсдэлтэй;
 - ХЭДС-ийн И-зөвшөөрөл буюу гадаадаас ажиллах хүч авах системд ажлын байрны төлбөрийн буцаалтын тооцоолол хийх модуль байхгүйн улмаас эксель программ дээр гадаадын иргэн бүрийн ажиллах зөвшөөрөлтэй хоног болон ажилласан хоногийн зөрүүг гараар тооцож, төлбөрийн буцаалтын тооцооллыг гаргаж байгаа нь үнэн зөв тооцоолол хийгдэхгүй байх, алдаа гарах эрсдэлтэй, санхүүгийн программ хангамжтай холбогдоогүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагаас 2024 онд авлагад тооцож авсан 36.6 сая төгрөгийн үнэ бүхий борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй, ашиглалтгүй хадгалагдаж байна. Жил ирэх бүр хөрөнгийн үнэ цэн буурснаар авлагын үлдэгдлээс 36.5 сая төгрөг нь бүрэн барагдахгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй гэж үзэн албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 47,678.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 47,029.7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлж, 648.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс 19,935.3 сая төгрөгийн 6 албан шаардлага, 648.5 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлт 70.5 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Биелээгүй		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	648,520.0	2	648,520.0	-	-	100.0
Албан шаардлага	9	47,029,705.7	6	19,286,742.4	3	27,742,963.2	41.0
Нийт дүн	11	47,678,225.7	8	19,935,262.5	3	27,742,963.2	70.5

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- ХЭДС-ийн 20,837.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөг барагдаж, нийт 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Авлагын 24.2 хувь буюу 4,629.0 сая төгрөгийг татан буугдсан Капитал банк, Анод банкны авлага эзэлж байгаа тул авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.
- Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн өмнөх оны үлдэгдэл 12,863.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлээс тайлант онд 36.0 хувь буюу 4,607.3 сая төгрөг барагдаж, 8,256.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тайлант онд тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч бүрэн барагдаагүй тул авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжид олгосон жижиг зээлийн хугацаа хэтэрсэн Шүүхийн шийдвэртэй 429.0 сая төгрөгийн авлагаас тайлант онд 7.3 хувь буюу 31.5 сая төгрөгийг барагдуулж, 397.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй, тайлант онд тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч бүрэн барагдаагүй тул авлагыг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад аудитын горим сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- ХЭДС-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон Санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэр байршуулж иргэдэд зээл олгохдоо зээлийн аппликэйшн ашигласанд гэрээгээр хүү тооцон батлуулж, зарцуулсан 36.2 сая төгрөгийн төлбөрийг актыг барагдуулаагүй. /Шүүхийн эцсийн шийдвэр гараагүй байна./
- Тайлант онд ХЭДС-ийн үндсэн үйл ажиллагааны орлого болох гадаад ажилтны ажлын байрны төлбөрт 215,362.0 сая төгрөгийн орлогыг аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрч, гүйцэтгэлээр 25,545.1 сая төгрөгийн хөнгөлөлт, буцаалтын төлбөрийг олгосон байна. Ажлын байрны хөнгөлөлт, буцаалтын төлбөрийг үнэн зөв, зохистой олгосон эсэхэд түүврийн горим сорил хэрэгжүүлсэн хэдий ч цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ХЭДС-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 275,019.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 20 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлантай холбоотой нийт 74,592.8 сая төгрөгийн 73 зөрчил² илэрсэнд 297.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 73,314.8 сая төгрөгийн зөрчилд 29 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 980.4 сая төгрөгийн зөрчилд 36 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 74,592.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 74,260.8 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

ХЭДС-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 34 сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 19 сангийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 6 сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” өгч, 9 сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Харьяа сангуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,170.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 12 алдаа² илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлан аудиттай холбоотой нийт 6,397.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 297.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 5,640.5 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, 459.5 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

ХЭДС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 272,849.1 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 8 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлан аудиттай холбоотой нийт 68,195.2 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 67,674.3 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 520.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтааж аж ахуйн нэгжүүдэд олгоогүй, холбогдох журмыг зөрчин он дамжуулан 6,350.0 сая төгрөгийг 108 аж ахуй нэгж, байгууллагад шилжүүлсэн байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Тухайлбал: Чайна энерги инженеринг групп ХХК-ээс 2024 оны ажлын байрны төлбөр болох 3,857.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 2024 оны оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хүсэлтийг гаргасан боловч холбогдох журмыг зөрчин он дамжуулан 2025 оны 04 дүгээр сард 2,206.7 сая төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах." 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.", ЗГ-ын баталсан 2023 оны "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам"-ын 99 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.1, 3.4-т заасан ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг тухай бүр судалж, шийдвэрлэнэ", 3.7-д "Энэ журмаар зохицуулсан ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэр нь тухайн төсвийн жилд хүчинтэй байна.", 4.3-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төлбөрийн зөрүү буцаан авах хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор энэ журмын 4.1-д заасан тохиолдлыг нотлох баримт бичиг болон гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тооцож, тухайн төсвийн жилд багтаан төлбөрийн зөрүүг буцаан олгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны ажлын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтаан аж ахуй нэгжүүдэд олгоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тус сангийн санхүүгийн тайланд тусгасан 2021 оны 26,422.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамтай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 5.1.5-д "хариуцлагатай байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн"; 5.1.4-д "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татаас санхүүжилтийн авлагыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тооцоо нийлж, авлагыг барагдуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Тайлант онд ХЭДС-ийн үндсэн үйл ажиллагааны орлого болох гадаад ажилтны ажлын байрны төлбөрт 215,362.0 сая төгрөгийн орлого аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрч, холбогдох журмын дагуу 25,545.1 сая төгрөгийн хөнгөлөлт, буцаалтын төлбөрийг олгожээ. Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Тухайлбал: 1. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн хариуцсан газраас хүргүүлсэн ажлын байрны төлбөрийн буцаалт олгох

тооцоолол болон ХЭДС-ийн санхүү хариуцсан мэргэжилтний тооцоолол 547.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгааг хариуцсан 2 нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь дараагийн шатны санхүүгийн болон дотоод хяналт сул байгаагаас шалтгаалан ажлын байрны буцаалтын төлбөр аж ахуйн нэгж, байгууллагад үнэн зөв олгогдохгүй эрсдэлтэй.

2. ХЭДС-ийн И-зөвшөөрөл буюу гадаадаас ажиллах хүч авах системд ажлын байрны төлбөрийн буцаалтын тооцоолол хийх модуль байхгүйн улмаас эксель программ дээр гадаадын иргэн бүрийн ажиллах зөвшөөрөлтэй хоног болон ажилласан хоногийн зөрүүг гараар тооцож, төлбөрийн буцаалтын тооцооллыг гаргаж байгаа нь үнэн зөв тооцоолол хийгдэхгүй байх, алдаа гарах эрсдэлтэй, санхүүгийн программ хангамжтай холбогдоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн;", 5.1.4-д "үнэн зөв байх;", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, буцаалтыг хариуцсан 2 нэгж тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 2016 онд үүссэн 2,565.6 сая төгрөгийн авлагаас 2024 онд авлагад тооцож авсан 36.6 сая төгрөгийн үнэ бүхий борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй, ашиглалтгүй хадгалагдаж байна. Жил ирэх бүр хөрөнгийн үнэ цэн буурснаар авлагын үлдэгдлээс 36.5 сая төгрөг нь бүрэн барагдахгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Санхүүгийн дэмжлэгээр олгосон зээлийн өмнөх оны авлагын үлдэгдлээс тайлант онд тодорхой хэмжээгээр барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч нийт 14,830.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй гарч, хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн өмнөх оны үлдэгдэл 12,863.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлээс тайлант онд 36.0 хувь буюу 4,607.3 сая төгрөг барагдаж, 8,256.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй.
2. Санхүүгийн дэмжлэгээр 2022 онд орон нутаг, нийслэлийн 4,420 иргэн аж, ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй 14,342.0 сая төгрөгийн олгосон зээлээс

тайлант онд хугацаа хэтэрсэн 2,154 иргэн, аж ахуй нэгжийн 6,574.4 сая төгрөгийн авлага үүссэн байна.

3. Санхүүгийн дэмжлэгийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, холбогдох журамд заасан санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлэхээр заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.“Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:” 6.4.8.“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх,” Аж ахуйн нэгж, байгууллагад эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний 4.5-д “Олгосон санхүүжилтийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 36 сарын хугацаанд 100% эргүүлэн төлнө.”, 4.6-д “Эргэн төлөлтийг гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор ХБХХЕГ-ын ХЭДС-ийн дансанд төвлөрүүлж, хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж тооцоо нийлнэ” Засгийн газрын 2021 оны 340 дүгээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.7-д “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ”. 6 дугаар зүйлийн 6.11-д “Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ.” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулах талаар харьяа байгууллагад холбогдох арга хэмжээг авч, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Дамжуулан зээлээр олгосон зээлийн өмнөх оны авлагын үлдэгдлээс 5.8 хувь буюу 1,180.1 сая төгрөг барагдаж, нийт 19,088.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Оёдлын нэгдсэн холбоонд 2013 онд олгосон 17,000.0 сая төгрөгийн зээлийн өмнөх оны үлдэгдэл 15,639.8 сая төгрөгийн авлагаас 7.5 хувь буюу 1,180.1 сая төгрөг барагдаж, 14,459.7 сая төгрөг;
2. Капитал банканд холбогдох хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгийн өмнөх оны чөлөөт үлдэгдэл 3,829.0 сая төгрөгөөс барагдуулалт хийгдээгүй;
3. Анод банканд 2005-2008 онд байршуулсан 800.0 сая төгрөгийн авлагаас барагдуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах талаар харьяа дээд шатны байгууллагатай санал хүргүүлж, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжид олгосон жижиг зээлийн хугацаа хэтэрсэн Шүүхийн шийдвэртэй 429.0 сая төгрөгийн авлагаас тайлант онд 7.3 хувь буюу 31.5 сая төгрөгийг барагдуулж, 397.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 340 дүгээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.7-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ", 6 дугаар зүйлийн 6.11-д "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолыг баримталж ажиллаагүй, зээлийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй, зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах талаар харьяа дээд шатны байгууллагатай санал хүргүүлж, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 8. ХЭДС-ийн харьяа 33 санд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,762.8 сая төгрөгийн 84 алдаа, зөрчил илэрснээс, санхүүгийн тайлагналтай холбоотой 2,170.2 сая төгрөгийн 12 алдаа, 6,397.6 сая төгрөгийн 63 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 7,195.0 сая төгрөгийн 9 зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", ЗГ-ын 2011 онд баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.", 5.3-д "Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, ... тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.", 5.4-д "Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Тайлант онд тус сангийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор постер хэвлүүлэх, үйл ажиллагааны тайланг хэвлүүлэх, цахим хуудсаар мэдээлэл, сурталчилгаа хийлгэх зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр 3 хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж урьдчилгаа санхүүжилтэд 32.0 сая төгрөгийг олгосон ч гүйцэтгэгч гэрээний үүргийг хангалтгүй хэрэгжүүлж, гэрээний үлдэгдэл санхүүжилт 21.4 сая төгрөгийг олгоогүй, өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, хэвлэлийн болон мэдээллийн үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхдээ гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

Илрүүлэлт 2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврыг зөрчин хөдөлмөрийн биржийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулахаар 1 хуулийн этгээдтэй 2025 оны 12 дугаар сарын 15-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 22.3 сая төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 25-нд олгожээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын 1.4.1-т хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр, шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх, 1.4.4-т "гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээг шинээр байгуулахгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан даалгавар болон дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 3. Тайлант онд Хөдөлмөрийн хувийн 55 биржид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 789.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосноос үндсэн чиг үүрэг болох ажилд зуучлах үйлчилгээнд 7.2 хувь буюу 56.8 сая төгрөгийг зарцуулж, харин ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад бүлгээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулахад 56.7 хувь буюу 447.1 сая төгрөгийг биржээс ирүүлсэн гүйцэтгэлийн дагуу хавтгайруулан олгосон нь зорилтот бүлэгтээ бүрэн хүрээгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэг төрлийн арга хэмжээний санхүүжилтийг хавтгайруулан олгодог зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналт, мониторингийг сайжруулах зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан-Төв сан	8	272,849,087.4	8	272,849,087.4			8	272,849,087.4				
2	Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	455,536.0			1	455,536.0	1	455,536.0				
3	Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	42,458.0	1	20,600.0	1	21,858.0	2	42,458.0				
4	Дархан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	84,000.0	1	84,000.0			1	84,000.0				
5	Говьсүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,120.0			1	1,120.0	1	1,120.0				
6	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	181,397.4			2	181,397.4	2	181,397.4				
7	Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	42,404.7			2	42,404.7	2	42,404.7				
8	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,363,275.6	2	236,048.9	1	1,127,226.7	3	1,363,275.6				
	Дүн	20	275,019,279.1	12	273,189,736.3	8	1,829,542.8	20	275,019,279.1				

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын санал дүгнэлт						Нийт зөрчлийн дүн		Үүнээс:							
		Үүнээс:								Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Хамрагдаагүй	Түүвэрт хамруулсан	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
1	ХЭДС Төв сан	1					1	10	68,195,176.9			7	67,674,336.3			3	520,840.6
2	АРА-ын ХЭДС	1	1					-	-								
3	БӨА-ын ХЭДС	1	1					-	-								
4	БХА-ын ХЭДС	1		1				12	153,903.1	5	21,465.0	5	132,438.1	1	-	1	-
5	БУА-ын ХЭДС	1					1	-	-								
6	ГАА-ын ХЭДС	1	1					-	-								
7	ГСА-ын ХЭДС	1	1					1	1,272.0			1	1,272.0				
8	ДАА-ын ХЭДС	1	1					-	-								
9	ДГА-ын ХЭДС	1					1	-	-								
10	ДОА-ын ХЭДС	1	1					1	1,079,286.7			1	1,079,286.7				
11	ДУА-ын ХЭДС	1					1	1	275,650.6	1	275,650.6						
12	ОРА-ын ХЭДС	1					1	4	183,534.0						4	183,534.0	
13	ЗАА-ын ХЭДС	1	1					1	624,820.2			1	624,820.2				
14	ӨВА-ын ХЭДС	1	1					-	-								
15	ӨМА-ын ХЭДС	1					1	-	-								
16	СҮА-ын ХЭДС	1					1	-	-								
17	СЭА-ын ХЭДС	1	1					1	4,500.0			1	4,500.0				
18	ТӨА-ын ХЭДС	1	1					2	31,423.0						2	31,423.0	
19	УВА-ын ХЭДС	1	1					-	-								
20	ХОА-ын ХЭДС	1	1					-	-								
21	ХӨА-ын ХЭДС	1	1					3	29,659.7			2	29,659.7			1	-
22	ХЭА-ын ХЭДС	1		1				1	70,000.0			1	70,000.0				
23	Нийслэлийн ХЭДС	1		1				5	121,414.3			2	78,925.0			3	42,489.3
24	БНД-ийн ХЭДС	1	1					2	2,640.0						2	2,640.0	
25	БХД-ийн ХЭДС	1	1					2	4,360.0						2	4,360.0	

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

26	БГД-ийн ХЭДС	1		1				3	28,820.0						3	28,820.0		
27	БЗД-ийн ХЭДС	1	1					2	2,940.0						2	2,940.0		
28	НД-ийн ХЭДС	1	1					2	3,030.0						2	3,030.0		
29	СХД-ийн ХЭДС	1		1				4	72,928.3			1	8,660.0		3	64,268.3		
30	СБД-ийн ХЭДС	1	1					2	416.0						2	416.0		
31	ХУД-ийн ХЭДС	1		1				3	43,227.0						3	43,227.0		
32	ЧД-ийн ХЭДС	1	1					2	906.0						2	906.0		
33	ХАХНХССХ - ХЭДС	1					1	5	2,219,249.5			5	2,219,249.5					
34	ХБХХЕГ- ХЭДС	1					1	4	1,443,652.1	1	500.0	2	1,391,660.0		1	51,492.0		
Дүн		34	19	6	-	-	-	9	73	74,592,809.4	7	297,615.6	29	73,314,807.6	1	-	36	980,386.2

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		тоо	дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан Төв сан	4	-			1	-			3	-
2	Хөвсгөл аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-							1	-
3	Дархан-Уул аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,993,881.9			1	3,993,881.9				
4	Говьсүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,500.0			1	3,500.0				
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар дэмжих сан	2	3,197,572.7			1	45,000.0			1	3,152,572.7
Дүн		9	7,194,954.6	-	-	4	4,042,381.9	-	-	5	3,152,572.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1094/АД16 1139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА - СТА - ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтааж аж ахуйн нэгжүүдэд олгоогүй, холбогдох журмыг зөрчин он дамжуулан 6,350,014,598.00 /зургаан тэрбум гурван зуун тавин сая арван дөрвөн мянга таван зуун ерэн найман/ төгрөгийг 108 аж ахуй нэгж, байгууллагад шилжүүлсэн байна. Тухайлбал: Чайна энержи инженеринг группээс 2024 оны ажлын байрны төлбөр болох 4,669,808,000.00 /дөрвөн тэрбум зургаан зуун жаран есөн сая найман зуун найман мянган/ төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс 2024 оны оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хүсэлтийг гаргасан боловч холбогдох журмыг зөрчин 2025 оны 4 дүгээр сард 2,206,677,000.00 /хоёр тэрбум хоёр зуун зургаан сая зургаан зуун наян найман мянган/ төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Монгол Улсын Засгийн газрын баталсан 2023 оны "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам"-ын 99 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.1, 3.4-т заасан ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг тухай бүр судалж, шийдвэрлэнэ", 3.7-д "Энэ журмаар зохицуулсан ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэр нь тухайн төсвийн жилд хүчинтэй байна.", 4.3-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төлбөрийн зөрүү буцаан авах хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор энэ журмын 4.1-д заасан тохиолдлыг нотлох баримт бичиг болон гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тооцож, тухайн төсвийн жилд багтаан төлбөрийн зөрүүг буцаан олгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-16.Docx

1526181382

1. Өмнөх оны ажлын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх шийдвэрийг тухайн төсвийн жилд багтаан аж ахуй нэгжүүдэд олгодоггүй зөрчлийг таслан зогсоож 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Мөнхжаргал/, Гадаадаас ажиллах хүч авах асуудал, тогтоол, шийдвэр, лавлагаа, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн /Б.Уранчимэг/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан мэргэжилтэн /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1095/АД161139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны санхүүгийн тайланд тусгасан 2021 оны 26,422,587,597.91 /хорин зургаан тэрбум дөрвөн зуун хорин хоёр сая таван зуун наян долоон мянга таван зуун ерэн долоон/ төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг Сангийн яамтай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 5.1.5-д "хариуцлагатай байх," , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн," 5.1.4-д "үнэн зөв байх," 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татаас санхүүжилтийн авлагыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

9006109
ATA15087
9025081411

Z:\Alban Shaardloga\2026\0325 SAG-16.Docx

1526181384



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1096/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА -СТА -ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагааны орлого болох гадаад ажилтны ажлын байрны төлбөрт 215,361,980,793.00 /хоёр зуун арван таван тэрбум гурван зуун жаран нэгэн сая есөн зуун наян мянга долоон зуун ерэн гурван/ төгрөгийн орлогыг аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрч, холбогдох журмын дагуу 25,545,088,406.00 /хорин таван тэрбум таван зуун дөчин таван сая наян найман мянга дөрвөн зуун зургаан/ төгрөгийн хөнгөлөлт, буцаалтын төлбөрийг олгожээ. Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Тухайлбал:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн хариуцсан газраас тооцоолсон ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, буцаалт олгуулах хүсэлт болон тус хүсэлтийг хянасан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү хариуцсан мэргэжилтний тооцоолол 547,777,042.00 /таван зуун дөчин долоон сая долоон зуун далан долоон мянга дөчин хоёр/ төгрөгөөр зөрүүтэй байгааг хариуцсан 2 нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд тооцоо нийлж баталгаажуулаагүй.

2. Тус сангийн И-зөвшөөрөл буюу гадаадаас ажиллах хүч авах систем нь санхүүгийн программ хангамжтай холбогдоогүйн улмаас эксель программ дээр гадаадын иргэн бүрээр ажиллах зөвшөөрөлтэй хоногийг тооцон, буцаалтын төлбөрийг олгож байгаа нь үнэн зөв тооцоолол хийгдэхгүй байх, ажлын байрны хөнгөлөлт, буцаалтын төлбөр аж ахуй нэгж, байгууллагад үнэн зөв олгогдохгүй эрсдэлтэй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн"; 5.1.4-д "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020

оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, буцаалтыг хариуцсан хоёр нэгж тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Гадаадаас ажиллах хүч авах асуудал, тогтоол, шийдвэр, лавлагаа, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн /Б.Уранчимэг/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан мэргэжилтэн /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

(Handwritten signatures in red ink)

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1097/А016 1139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Капитал банкны эрх хүлээн авагчаас 2024 онд авлагад тооцож авсан 36,550,000.00 /гучин зургаан сая таван зуун тавин мянган/ төгрөгийн үнэ бүхий борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй, ашиглалтгүй хадгалагдаж байна. Жил ирэх бүр элэгдэл хорогдолд орж, хөрөнгийн үнэ цэнэ буурах нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Борлуулах зориулалттай авто тээврийн хэрэгслийг худалдан борлуулаагүй зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-16.Docx

1526181388



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1098/АД161139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Санхүүгийн дэмжлэгээр 2016-2021 онд орон нутаг, нийслэлийн иргэн аж, ахуй нэгжид гурван жилийн хугацаатай хүүгүй олгосон зээлийн хугацаа хэтэрсэн өмнөх оны үлдэгдэл 12,863,771,440.00 /арван хоёр тэрбум найман зуун жаран гурван сая долоон зуун далан нэгэн мянга дөрвөн зуун дөчин/ төгрөгийн зээлээс тайлант онд 36.0 хувь буюу 4,607,348,860.06 /дөрвөн тэрбум зургаан зуун долоон сая гурван зуун дөчин найман мянга найман зуун жаран/ төгрөг барагдаж, 8,256,421,607.00 /найман тэрбум хоёр зуун тавин гурван сая дөрвөн зуун хорин нэгэн мянга зургаан зуун долоон/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй.

2. Санхүүгийн дэмжлэгээр 2022 онд орон нутаг, нийслэлийн 4,420 иргэн аж, ахуйн нэгжид 3 жилийн хугацаатай хүүгүй 14,341,955,649.00 /арван дөрвөн тэрбум гурван зуун дөчин нэгэн сая есөн зуун тавин таван мянга зургаан зуун дөчин есөн/ төгрөгийн олгосон зээлээс тайлант онд хугацаа хэтэрсэн 2,154 иргэн, аж ахуй нэгжийн 6,574,444,865.00 /зургаан тэрбум таван зуун далан дөрвөн сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун жаран таван/ төгрөгийн авлага үүссэн байна.

3. Санхүүгийн дэмжлэгийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, холбогдох журамд заасан санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх," Засгийн газрын 2021 оны 340 дүгээр "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.7-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ", 6 дугаар зүйлийн 6.11-д "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230


Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-16.Docx

1526181390

оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулах талаар харьяа байгууллагад холбогдох арга хэмжээг авч, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах, зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн /Л.Санжсүрэн/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1099/АД161139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дамжуулан зээлээр олгосон зээлийн өмнөх оны авлагын үлдэгдлээс 5.8 хувь буюу 1,180,143,677.00 /нэг тэрбум нэг зуун наян сая нэг зуун дөчин гурван мянга зургаан зуун далан долоон/ төгрөг барагдаж, нийт 19,088,714,952.00 /арван есөн тэрбум наян найман сая долоон зуун арван дөрвөн мянга есөн зуун тавин хоёр/ төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Оёдлын нэгдсэн холбоонд 2013 онд олгосон 17,000,000,000.00 /арван долоон тэрбум/ төгрөгийн зээлийн өмнөх оны үлдэгдэл 15,639,828,819.00 /арван таван тэрбум зургаан зуун гучин есөн сая найман зуун хорин найман мянга найман зуун арван есөн/ төгрөгийн авлагаас 7.5 хувь буюу 1,180,143,677.00 /нэг тэрбум нэг зуун наян сая нэг зуун дөчин гурван мянга зургаан зуун далан долоон/ төгрөг барагдаж, 14,459,685,142.00 /арван дөрвөн тэрбум дөрвөн зуун тавин есөн сая зургаан зуун наян таван мянга нэг зуун дөчин хоёр/төгрөг;

2. Капитал банкинд холбогдох хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгийн өмнөх оны чөлөөт үлдэгдэл 3,829,029,810.00 /гурван тэрбум найман зуун хорин есөн сая хорин есөн мянга найман зуун арван/ төгрөгөөс барагдуулалт хийгдээгүй;


3. Анод банкинд 2005-2008 онд байршуулсан 800,000,000.00 /найман зуун сая/ төгрөгийн авлагаас барагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах талаар харьяа дээд шатны байгууллагатай санал хүргүүлж, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авах, зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1100/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг үндэслэн 2003-2017 онд олгосон зээлээс нийт 11 иргэн, аж ахуй нэгжид олгосон жижиг зээлийн хугацаа хэтэрсэн Шүүхийн шийдвэртэй 428,983,676.00 /дөрвөн зуун хорин найман сая есөн зуун наян гурван мянга зургаан зуун далан зургаан/ төгрөгийн авлагаас тайлант онд 7.3 хувь буюу 31,472,003.00 /гучин нэгэн сая дөрвөн зуун далан хоёр мянга гурван/ төгрөгийг барагдуулж, 397,511,673.00 /гурван зуун ерэн долоон сая таван зуун арван нэгэн мянга зургаан зуун далан гурван/ төгрөгийн авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 340 дүгээр төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.7-д "Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь санхүүгийн дэмжлэгт хамрагдах этгээдтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлан мэдээг гаргах, эргэн төлөлт, хариуцлага, хяналтын асуудлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэнэ", 6 дугаар зүйлийн 6.11-д "Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг хууль бусаар ашигласан, эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийн бүртгэл хөтөлж олон нийтэд мэдээлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолыг баримталж ажиллаагүй, зээлийг эргэн төлөөгүй, гэрээний үүргээ зөрчсөн этгээдийг олон нийтэд мэдээлээгүй, зөрчлийг арилгаж, авлагын үлдэгдлийг 30-аас доошгүй хувиар барагдуулах арга хэмжээг авч 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264 30

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-16.Docx

1526181394

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1101/АД16.1139

Улаанбаатар хот

САГ-2026/21/НА-СТА -ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн харьяа 33 санд 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,762,778,765.79 /арван таван тэрбум долоон зуун жаран хоёр сая долоон зуун далан найман мянга долоон зуун жаран таван/ төгрөгийн 80 алдаа, зөрчил илэрснээс, санхүүгийн тайлагналтай холбоотой 2,170,191,681.00 /хоёр тэрбум нэг зуун далан сая нэг зуун ерэн нэгэн мянга зургаан зуун наян нэгэн/ төгрөгийн 12 алдаа, 6,397,632,468.79 /зургаан тэрбум гурван зуун ерэн долоон сая зургаан зуун гучин хоёр мянга дөрвөн зуун жаран найман/ төгрөгийн 63 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 7,194,954,616.00 /долоон тэрбум нэг зуун ерэн дөрвөн сая есөн зуун тавин дөрвөн мянга зургаан зуун арван зургаан/ төгрөгийн 5 зөрчил илэрсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2011 онд баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ.", 5.3-д "Сангийн зарцуулалтад Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналт, ... тус тус эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.", 5.4-д "Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авах, зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт биелэлтийг ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264-30

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-16.Docx

1526181396

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Бауыржан/, Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч /Г.Оюун/, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Гулзат/, Хяналт, шалгалт, дотоод аудит мониторингийн газрын дарга /М.Мянганбуу/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Д.НОМИНГУА